



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 9/96

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 51 дүгээр зүйлийн 51.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Баян-Овоо, Норовлин, Батноров сумдын нутагт гарсан мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчнийг цомхотгон дарах үйл ажиллагааны зардал, болон Өмнөдэлгэр, Батширээт, Баян-Адарга, Биндэр сумын тарилгын зардлыг тооцож олгосугай.
2. Сумдын нэр, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.
3. "Шүлхий" өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны зардал 10000000 /арван сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н. ГАНБАЯМБА

01 485

Аймгийн Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 07 өдрийн 0196
дугаар захирамжийн хэвсрэлт



Сумдын нэр, мөнгөн дүн

№	Сумдын нэрс	Мөнгөн дүн
1	Баян-Овоо	2000000
2	Батноров	2000000
3	Норовлин	2000000
4	Биндэр	800000
5	Баян-Адарга	800000
6	Өмнөдэлгэр	1000000
7	Батширээт	700000
8	Онцгой комисс	700000
Нийт		10000000